

## Зээлийн зарласан болон бодит хүү

*Судалгааны Хэлтсийн эдийн засагч*

*Д. Дуулал*

Зээлжүүлэлт нь банкны үндсэн үйл ажиллагаа бөгөөд эрсдэлийн гол асуудлын нэг юм. Банк санхүүгийн зах зээл дээр амжилттай ажиллаж байгаа банкны зээлийн бодлого нь зээл олгохдоо гол нь биш тэдгээрийн эрсдэлийг хамгийн бага түвшинд байлган, зээлийн үндсэн өр, хүүгийн хамтаар эргэн төлүүлэх явдал байдаг. Банкны үр ашигтай ажиллах гол үндэс нь эрсдэлийг хамгийн бага түвшинд, оновчтой удирдах юм. Иймээс банкууд зээлийн эрсдэлийг хэрхэн үр дүнтэй, оновчтой удирдаж байгаагаас шалтгаалан банкуудын оршин тогтнох, зах зээл дээр өрсөлдөх үндэс нь болж өгдөг. Банк санхүүгийн зах зээлийн байдал болон зээлийн эрэлт, нийлүүлэлтээс шалтгаалан зээлийн хүүг тогтоодог гол байгууллага нь арилжааны банкууд юм. Нөгөөтэйгүүр Төв банк нь мөнгөний бодлогоороо /Төв банкны үнэт цаасны хүү, мөнгөний нийлүүлэлт гэх мэт/ дамжуулан зах зээл дээрх бусад хүүнүүдэд дохио өгөх бөгөөд зээл, хадгаламжийн хүүнд харилцан адилгүй нөлөө үзүүлдэг.

Зээлийн хэмжээ, тоо, төрөл нэмэгдсэн ч иргэд, байгууллагын хувьд зээлийн эрэлт нь урьдын адил өндөр хэвээр байна. 2006 онд Монголбанкнаас явуулсан нийгэм эдийн засгийн түүвэр судалгаанд хамрагдсан иргэдийн 82.6 хувь зээлийн хэрэгцээ их байдаг гэж хариулсан нь үүнийг нотолж байна. Мөн манай улсад хөрөнгийн захын хөгжил сул дорой байгаагаас бизнес эрхлэгчдийн хувьд санхүүгийн эх үүсвэр олж авах боломж хязгаарлагдаж, банкны салбарт ачаалал хэт төвлөрч байна. Иймээс банкууд зээлийн хүүгээ бууруулах сонирхолгүй, нөгөөтэйгүүр сүүлийн жилүүдэд их хэмжээгээр бий болж буй ББСБ, ХЗХ-ын эх үүсвэрийн төлөөх тэмцэл, татварын дарамт нь хүүний түвшинг өндөр хэвээр байлгахад нөлөөлж байна.

Монголбанк сар бүрийн Мөнгөний статистик мэдээндээ банкуудын төгрөг болон валютын зээлийн жигнэсэн дундаж хүүг тооцон гаргадаг. Энэ нь банк зээлдэгч хоёр зээлийн харилцаанд эхэлж орох үеийн буюу банк зээлдэгчээс авахаар урьдчилан тохиролцсон хүү юм. Дээрх хүү нь 2006 оны 8 дугаар сард төгрөгийн хүү жилийн 28.1 хувь байгаа нь тухайн сард банкуудаас харилцагчиддаа олгосон төгрөгийн зээлийн хүүг олгосон зээл тус бүрийн дүнгээр жигнэж тооцсон хүү юм. Валютынх 16.3 хувь байна.


Мөн Монголбанк банкуудаас орлого зарлагын тайлан мэдээг сар тутам хүлээн авдагт банкууд зээлдэгчээсээ бодитойгоор төлүүлж авсан зээлийн хүүний орлогын мэдээ багтдаг. Энэхүү мэдээн дэх тухайн үеийн хүүний орлогыг тухайн үеийн эцсийн зээлийн үлдэгдэл болон өмнөх оны эцсийн зээлийн үлдэгдлийн арифметик дундаж хувааж, банк тухайн сарын зээлээсээ бодитоор олж авсан хүүний түвшинг энэ судалгааны ажилд тооцож гаргалаа. Зээлийн бодит хүү нь банкууд олгосон зээлээсээ бодитойгоор яг ямар хүү төлүүлэн авч байгааг тодорхойлдог. Энэ нь зээлийн зарласан хүүнээс ялгаатай. Учир нь зээл эргэн төлөгдөхгүй байх, хугацаа хэтрэх, чанаргүй болох тохиолдолд үндсэн төлбөр болон түүний хүүг банкууд авч чадахгүйд хүрдэг. Иймд банкууд анх зарласан хүүгээрээ орлого олж чаддаггүй.

2000-2005 онуудын жилийн эцэс, 2006 оны 8 дугаар сарын банкуудын орлого зарлагын мэдээг үндэслэн зээлийн өрийн үлдэгдэлд төлөгдөж буй бодит хүүг банкны салбарын хэмжээгээр Хавсралт 1-д тооцон зээлийн зарласан хүүтэй харьцуулан үзүүлэв. Хавсралт 3,4,5-д банк тус бүрээр тооцож үзүүлэв. Хавсралт 2-д банкуудын хадгаламжийн жилийн хүү /банкуудын хадгаламжийн хүү гэдэгт төгрөгийн хугацаатай хадгаламжийн дээд, доод хүүгийн түвшний арифметик дунджийг авав/ болон зээлийн бодит жилийн хүүтэй харьцуулан үзүүлэв. Банкуудын орлого, зарлагын тайлан мэдээнд төгрөг, валютын хүүний орлогыг хамтад тооцсон байдаг тул банкуудын зээлийн зарласан хүү гэдэгт төгрөг, валютын зээлийн жигнэсэн дундаж хүүгийн арифметик дундаж хүүг авч тооцов. Төгрөг, валютын зээлийн жигнэсэн дундаж хүүгийн арифметик дундаж нь 2006 оны 8 дугаар сарын байдлаар жилийн 22.2 хувь байна.

Банкуудын 2000-2003 онуудын орлого зарлагын тайлангаас хүүгийн орлого гэсэн зүйл ангиас “зээлийн хүүгийн орлого”, “хугацаа хэтэрсэн зээлийн хүүний орлого” гэсэн хоёр зүйл ангийн нийлбэрийг авч, ЗГ-н үнэт цаас, Монголбанк болон бусад банкнаас авсан хүүгийн орлого, банк хоорондын зах болон гадаадын банкнаас авсан хүүний орлого зэргийг оруулаагүй болно. Харин 2004 оноос банкуудын орлого зарлагын тайлангийн маягт өөрчлөгдсөнөөр зээлийн хүүгийн орлого гэсэн бүлгээс Монголбанк, бусад банк санхүүгийн байгууллагаас авсан хүүг хасаж тооцов.


Хавсралт 1-с харахад 2000 оноос 2001 оны 7 дугаар сарын хугацаан дахь банкуудын зээлийн зарласан хүү болон зээлийн бодит хүү хоёрын хоорондын зөрүү их байсан ба 2000 оны 1 дүгээр сард хамгийн дээд /24.0 нэгж/ түвшиндээ хүрсэн байна. Эндээс үзэхэд банк зээлдэгч хоёрын анх тохиролцож байсан хүүнээсээ хамаагүй доогуур зээлийн хүүг зээлдэгч эцэстээ банкинд төлдөг байв. Жишээ нь: Зээлийн зарласан хүү 2000 оны 4, 5 саруудад харгалзан 33.4, 32.0 хувьтай байхад бодит хүү нь 16.4,16.1 хувь байна. Мөн зарим банкууд зээлийн зарласан хүүг буруу ташаа гаргаж өгөх, нөгөө талаас Монголбанкны банкуудаас авч байгаа хүүний мэдээллийн хүснэгтэд агуулагдаж байгаа зээл, хүүгийн талаарх мэдээлэл хангалтгүй байж болох талтай. Дээрх хоёр хүүгийн зөрүү 2001 оны хагасаас багасаж, зээлийн өрийн үлдэгдэлд төлөгдөж буй бодит хүүгийн түвшин дээшилж, улмаар 2005, 2006 онуудад зээлийн бодит хүүгийн түвшин тогтмол 20 орчим хувьтай байна. Энэ нь банкууд дунджаар сарын 1.66 хүүтэй зээл олгож байна гэсэн үг.

*Зураг 1. Банкуудын зээлийн хүү /жилийн, хувиар/*



Зураг 1-ээс харахад нийт банкуудын зээлийн зарласан болон бодит хүүний зөрүү сүүлийн жилүүдэд тогтвортой буурах хандлагатай байгаа бөгөөд 2000 оноос 2006 оны 8 дугаар сар хүртэл тогтмол буурсан бөгөөд жилийн дунджаар үзэхэд дээрх хугацааны хооронд бараг 9.0 дахин буурсан. Энэхүү бууралтын гол шалтгаан нь хадгаламжийн хүү харьцангуй тогтвортой байхад зээлийн хүү буурсан, мөн банкууд зээлийн зарласан хүүгээ бодит хүүгийн түвшинд зарладаг болсонтой холбоотой байна. Банкуудын хадгаламжийн жилийн дундаж хүү 2000 оноос бусад онуудад зээлийн дундаж хүүнээсээ бага байна Хавсралт 2-ыг үзнэ үү. Банкуудын зээл болон хадгаламжийн хүүний зөрүү сүүлийн жилүүдэд буурах хандлага ажиглагдаж буй хэдий ч зөрүү нь өндөр хэвээр байна. Энэ нь манай орны хувьд банкуудын нийт орлогын ихэнх хэсгийг зээлийн хүүгийн орлогоос, мөн түүний зардлын дийлэнх нь хадгаламжийн хүүний зардал байдагтай холбоотой /2005 оны эцэст зээлийн хүүний орлого нийт хүүний орлогын 91.8 хувийг эзэлж байсан бол мөн тухайн үед харилцах, хадгаламжийн хүүний зардал нийт хүүний зардлын 90.5 хувийг эзэлж байна/. Том банкууд нь өөрийн нийт орлогын дийлэнх хэсгийг зээлийн хүүгээс оруулж байхад жижиг банкууд нь өөрийн үйл ажиллагааг санхүүжүүлэх зорилгоор мөнгөний зах зээл дээрээс том банкууд шиг мөнгөн зээл авалгүйгээр татан төвлөрүүлсэн хөрөнгөнд найдвар тавьж үйл ажиллагаа явуулдаг байна. Ийм учраас том банкуудыг бодвол жижиг банкууд нь татан төвлөрүүлсэн хөрөнгийн хүүний хэлбэрээр харьцангуй их зардал гаргадаг. Банкуудын хүүний зөрүү бага байх нь санхүүгийн зуучлалын зардал бага, үр өгөөжтэй байгааг харуулдаг.


Зураг 2. Банкуудын зээлийн дундаж бодит хүү ба хадгаламжийн дундаж хүү /жилийн, хувиар/



Зураг 2-оос харахад сүүлийн жилүүдэд банкууд хадгаламжийн хүүгээ ойролцоогоор 7 орчим нэгжээр нэмэгдүүлж зээл олгож байна. 2002 онд 11.8 нэгжээр нэмж ашиг олж байсан бол 2006 оны 8 дугаар сард 7.2 нэгж болж буурчээ. Хадгаламж, зээлийн хүүний зөрүү багасаж байгаа нь банкны салбарын хадгаламж нэмэгдэж, улмаар банкуудын зээл олгох эх үүсвэр өсч, зах зээлд зээлийн шинэ бүтээгдэхүүн нэвтрүүлснээр, банкуудын өрсөлдөөн нэмэгдэж, зээл, түүний барьцаа тойрсон хууль эрх зүйн орчин сайжирсантай холбоотой юм. Зөрүү ашгийн /spread/ тусламжтайгаар банкууд нь хадгаламж эзэмшигч, зээлдэгчийн хооронд зуучлагчийн үүргээ хэрхэн биелүүлж байгааг, банкны үйлчилж буй зах зээлийн өрсөлдөөн хэр зэрэг хурц байгааг үнэлдэг, банкны ашигт ажиллагааны түвшний үзүүлэлтийн нэг юм. Өрсөлдөөн хичнээн ширүүн болох тусам активын дундаж орлого, пассивын дундаж зардал хоёрын ялгааны зөрүү багасдаг.

Банкны салбарын хэмжээгээр зээлийн зарласан хүү болон бодит хүүгийн зөрүү 2000 оноос 2002 оны хооронд 6.7 дахин буурсан байна. 3-н том банкны зөрүү мөн хурдацтай буураад өсөх хандлагатай байгаа бөгөөд 4-н дунд, 8-н жижиг банкны хувьд өсөөд, буурах хандлагатай байна. Энэ нь 1990 онуудын банкуудын дараалсан хямралыг гэтлэн давсанаар, банк санхүүгийн салбар эрүүлжин тогтворжин, банкуудын зээл, активын хэмжээ хурцадтай өсч, банкууд зээлийн хүүгээ зах зээлийн эрэл нийлүүлэлтэнд зохицуулан бодиттойгоор тогтоож эхэлсэнтэй холбоотой байна. Мөн эдийн засгийн орчин сайжирч, банкуудын ажилтнуудын ажлын ур чадвар дээшилсэн зэргээс шалтгаалан банкууд зээлдэгчийн төлбөрийн чадвартай холбоотой эрсдэлийг тооцож, зээлдэгчийн өмнөх түүхийг судлах, тухайн үеийн санхүүгийн байдлыг үнэлэх, ирээдүйн төлөв, зээлийг буцаан төлөх боломж, хугацаа зэрэг асуудлыг сайтар судалдаг болсон.


*Зураг 3. Банкуудын зээлийн зарласан хүү болон бодит хүүгийн зөрүү, банкуудаар /жилийн, хувиар/*



Зээлийн зарласан хүүг 2000 онд банкууд жилийн 19.4-96.0 хувийн хүүтэйгээр зарлаж, зээлдэгчидтэйгээ анх тохиролцож байжээ. Харин тухайн үед зээлийн үлдэгдэлд төлөгдөж буй бодит хүүгийн түвшин нь жилийн 6.3-45.3 хүүтэй байгаа нь зарласан хүүгээс даруй 2-3 дахин бага байна. 2001, 2002 онуудад зээлийн зарласан болон бодит хүүгийн түвшний зөрүү харьцангуй багасчээ.


Банкуудын зээлийн зарласан жилийн хүү 2003-2006 онуудын хооронд ойролцоо /дунджаар 22.5/ түвшинд буюу нийт банкуудын зарласан хүү 34.7-10.3 хувийн хүүтэйгээр зарлаж байжээ. Банкуудын зээлийн зарласан хүү 2003 оноос 2006 оны 8 дугаар сар хүртэл 4-н том банкны хувьд 4.6 нэгжээр, 4-н дунд банк 2.0 нэгжээр, 9-н жижиг 6.5 нэгжээр тус тус буурч, зээлийн бодит хүү рүүгээ дөхөж ирсэн байна. Энэ нь сүүлийн жилүүдэд инфляцийн түвшин багасч тогтворжин, түүнийг даган хадгаламжийн хүү буурснаар, банк санхүүгийн зах зээл дээр банкуудын өрсөлдөөн ширүүсэн, эдийн засаг дахь зээлжүүлэлт нэмэгдэж, банкууд зээлийн зарласан хүүгээ бодитойгоор тогтоож эхэлсэн байна.

*Зураг 4. Банкуудын зээлийн зарласан хүү /жилийн, хувиар/*



9-н жижиг банкуудын зээлийн зарласан жилийн хүүг бусад банкуудтай харьцуулахад өндөр байгаа нь зарим жижиг банкууд байгуулагдаад удаагүй байсан тул бусад банкуудаасаа илүү хүүгээр татан төвлөрүүлсэн хөрөнгийг хуримтлуулах, зээлээ шинээр гаргаж зах зээл эзлэх алхам эхэлж байсантай холбоотой юм. Нөгөө талаар жижиг банкууд зээлийн хүүгээ бууруулах нь жижиг банкуудын хувьд ашиггүй байгаа учраас тэд зээлийн хүүгээ өөрчлөхийг хүсэхгүй. Учир нь зээлийн хүү буурахын хэрээр жижиг банкуудын зардал өссөний улмаас ашигт нөлөөлнө.


Зураг 5. Банкуудын ашигт ажиллагаа ба зээлийн хүү/жилийн, хувиар/



Банкны салбарын хэмжээгээр 2001 оноос 2005 онуудын хороонд актив болон өөрийн хөрөнгийн өгөөж буурч, зээлийн зарласан ба бодит хүүний зөрүү эрс багасаж иржээ. Сүүлийн жилүүдэд банкуудын хооронд эрүүл өрсөлдөөн нэмэгдэн, банкуудын актив болон өөрийн хөрөнгө эрчимтэй өсч, өсөлт нь ашгийн өсөлтөөс илүү хурдтай байсан нь цэвэр ашиг ба актив, өөрийн хөрөнгийн харьцаа буурахад нөлөөлжээ.

Зураг 6. Банкуудын зээлийн бодит хүү

/жилийн, хувиар/



Нийт банкны салбарын хэмжээгээр банкуудын зээлийн бодит жилийн хүү сүүлийн 4 жилийн дунджаар жилийн 22.05 хувь /сарын 1.84 хувь/-тай байна. 4-н том банкны зээлийн бодит жилийн хүү нь бусад банкуудаасаа бага байгаа нь эдгээр том банкууд цөөн тооны найдвартай зээлдэгчдэд бага хүүтэй зээл олготой холбоотой байна. Энэ нь том банкуудын татан төвлөрүүлсэн хөрөнгөд төлдөг хүү нь жижиг банкуудын түвшингээс бага байдагтай холбоотойн дээр том банкуудын эрсдлийг удирдах болон өмнөх үеийн туршлага нь макро орчны сөрөг нөлөөллөл, эрсдлийн үнэлгээг хэт өндөр хүүндээ шингээдэггүйтэй холбоотой байж болох юм.

9-н жижиг банкны зээлийн бодит жилийн хүү нийт банкны салбарын болон бусад ангиллын банкуудаасаа өндөр байна. Энэ нь анх байгуулагдаад удаагүй байсан зарим жижиг банкуудын үйл ажиллагаа сүүлийн 2 жилд жигдэрч, банкууд хүүгээ зарлахдаа том банкуудтай ойролцоо зарлахтай болсонтой холбоотой байж болохоор байна. Мөн жижиг банкууд бичил жижиг зээлийг санхүүжүүлдэг үүднээс тус зээлийн өндөр өртгөөс шалтгаалдаг байна.

2006 оны 8 сарын байдлаар 4-н том, 4-н дунд, 9 жижиг банкуудын зээлийн бодит жилийн хүү 13.4, 13.5, 14.1 хувийн хүүтэй байгаа нь 2000 оноос хойш тогтмол буурч, банкуудын хүүний түвшин ойролцоо болсон байна. Энэ нь банкууд зээлийн бүтээгдэхүүний өрсөлдөөн нэмэгдэж, зээлийн хүүгээ шат дараалан бууруулах арга хэмжээ авч байгаатай холбоотой юм. Мөн банкууд урт хугацааны хөрөнгө оруулалт, ялангуяа орон сууцны зээлийг харьцангуй бага хүүтэйгээр, урт хугацаагаар олгож эхэлж байгаа нь нөлөөлж болох талтай байна.

Хүснэгт 1.ХААН, ХАС банкуудын үзүүлэлтүүд /жилийн, хувиар/

	2000		2001		2002		2003		2004		2005		2006-VIII	
	ХААН	ХАС	ХААН	ХАС	ХААН	ХАС	ХААН	ХАС	ХААН	ХАС	ХААН	ХАС	ХААН	ХАС
Зээлийн зарласан хүү	60.0	-	59.9	-	34.0	44.0	30.3	29.1	31.6	27.4	27.2	25.0	23.8	25.5
Зээлийн бодит хүү	6.3	-	29.5	-	40.3	22.2	34.1	21.6	31.4	18.3	28.6	16.1	19.4	9.7

Хадгаламжийн хүү	9.6	-	10.2	-	12.6	15.3	14.4	15.6	14.4	15.0	14.4	14.4	14.4	14.4
------------------	-----	---	------	---	------	------	------	------	------	------	------	------	------	------

1990-ээд оны сүүлчээр санхүүгийн хямралд орсон ХААН банкны менежментийн багыг гадны байгууллага авч, улмаар хувьчилагдан үйл ажиллагаа нь сайжирч эхэлсэн, 2002 оноос бичил санхүүгийн зээлээр мэргэшиж бий болсон ХАС банкууд банк санхүүгийн зах зээлд дээр амжилттай ажиллаж байна. 2000 оноос ХААН, ХАС банкуудын зээлийн зарласан хүү 2000 онд ойролцоо 60, 59.9 хувьтай байсан ба 2000 оноос 2006 оны 8 дугаар сарын хооронд харгалзан 2.5, 2.3 дахин буурчээ. Бодит хүү нь 2006 оны 8 дугаар сард зарласан хүүнээс 4.4, 15.8 нэгжээр бага байна. Энэ нь бичил зээлийн үйл ажиллагааг бусад банкуудаасаа илүү түлхүү явуулдаг ХААН, ХАС банкууд Улаанбаатар, хөдөө орон нутгын бүх нутаг дэвсгэрт өөрийн салбар нэгжтэй, бичил зээлийн хэмжээ нь бага боловч зээлдэгчийн тоо нь олныг хамарч байдаг, мөн бичил зээлийг шат дараалан авахаар зээлийн хүү буурдаг нь тус 2 банкны зээлийн хүү сүүлийн жилүүдэд тогтмол буурсаар байна.


Банкуудын зээлийн зарласан болон бодит хүүгийн зөрүү сүүлийн жилүүдэд багасаж байгаа хэдий ч зарласан болон бодит хүүний зөрүү зээлдэгчдэд хэрхэн тусдагыг ХХБ - ны 2006 оны 8 дугаар сарын зээлийн хүү дээр тооцож хийсэн хийсвэр энгийн жишээг Хүснэгт 2-д үзүүлэв. Иргэн А өөрийн бизнесийн үйл ажиллагаа явуулахын тулд ХХБ-наас 10 сая төгрөгийн зээлийг 1 жилийн хугацаатай зээлжээ. Иргэн А тус банкнаас зээлийн зарласан хүүгээр зээл авахад сарын 155,833.3 төгрөг, жилийн 1,870,000.0 төгрөгийн хүү төлөхөөр байна. Харин бодит хүүгээр тооцоход сарын 85,833.3 төгрөг, жилийн 1,030,000.0 төгрөгийн хүү төлж байна. Эндээс харахад сарын 70,000.0 төгрөг, жилийн 840,000.0 төгрөгийн зөрүү байгаа нь банкууд зээлийн хүүгээ эрэлт нийлүүлэлт болон бусад хүчин зүйлсээр зохицуулан бодитой тогтоох нь зээлдэгчдэд үүрэх ачаа хэрхэн хөнгөрдөгийг харж болохоор байна.

*Хүснэгт 2.ХХБ-ны зээлийн хүү /төгрөг, хувиар/*

<i>2006 оны 8 дугаар сар</i>			
	Зээлийн хэмжээ	1 сарын	Жилээр
Зээл	10,000,000.00		
Зээлийн зарласан хүү /жилийн/	18.7		
Зээлийн бодит хүү /жилийн/	10.3		
Зээлийн зарласан хүү /сарын/		1.6	
Зээлийн бодит хүү /сарын/		0.9	
Төлөх хүү /зарласан хүүгээр/		155,833.33	1,870,000.00
Төлөх хүү /бодит хүүгээр/		85,833.33	1,030,000.00
<b>Зөрүү</b>		70,000.00	840,000.00

*Зураг 7.Шилжилтийн эдийн засагтай орнуудын зээлийн хүү /жилийн, хувиар/*





Эх сурвалж: EBRD "Transition report 2005"

Төв ба Зүүн Европын болон ТТУХН улсуудын зээлийн хүүг жигнэсэн дундаж хүүгээр авав.

Зураг 7-с харахад Төв ба Зүүн европын орнуудын зээлийн жилийн хүү бусад шилжилтийн эдийн засагтай орнуудаасаа харьцангуй бага бөгөөд жил ирэх тусам зээлийн жигнэсэн дундаж хүү нь буурч байна. Төв ба Зүүн европын орнуудаас Чех, Эстон, Литва, Словак улсууд хамгийн бага зээлийн хүүтэй байна. Хамгийн өндөр нь Румын улс байна. Хавсралт 5-с харна уу.

ТТУХН-н орнуудын зээлийн жигнэсэн дундаж хүү мөн буурах хандалагатай байгаа ба 2000, 2001 оны зээлийн хүү нь Монгол улсын бодит хүүнээс өндөр байна. Ерөнхийдөө ТТУХН-н орнууд болон Монгол улсын зээлийн хүү ойролцоо түвшинд буюу Беларус, Гүрж, Киргиз улсууд Монгол улсын зээлийн хүүнээс өндөр түвшинд байна.

Манай улсын зээлийн зарласан жилийн хүү 2001 оноос тогтмол буурч, зээлийн бодит хүүтэйгээ ойролцоо түвшинд буюу 2006 оны 8 дугаар сарын байдлаар зээлийн зарласан жилийн хүү 21.6 хувь, бодит хүү 20.5 хувь болжээ. Сүүлийн 6 жилийн хувьд зээлийн жилийн бодит хүү 2002, 2003 онуудад хамгийн өндөр /24.8, 24.5/ түвшиндээ хүрсэн байхад инфляцийн жилийн түвшин 1.6, 4.7 хувьтай байв. 2004, 2005 онуудад инфляцийн түвшин /11.0, 9.5/ өссөн байхад зээлийн бодит хүү аажмаар /22.9, 20.5/ буурчээ. Эндээс үзэхэд инфляцийн жилийн түвшин өсч байхад зээлийн бодит жилийн хүү эсрэгээрээ буурч байна. 2000 оноос хойших инфляци, зээлийн зарласан болон бодит хүүний хандлагыг харахад, инфляцийн өөрчлөлт бараг нэг түвшинд, харин зээлийн хүү буурах хандлагатай байна. Банкуудын зээлийн хүүний өөрчлөлт инфляцийн өөрчлөлттэй шууд холбоогүй байна.

## Дүгнэлт

Төв банк мөнгөний бодлогын хэрэгслээр дамжуулан мөнгө, зээлийн хэмжээг удирддаг. Харин мөнгөний бодлогын хэрэнслүүд нь зээлийн нийлүүлэлтэд

нөлөөлөхөөс эрэлтэд шууд нөлөө үзүүлдэггүй. Иймд Төв банкуудад хүүний хэмжээг бүрэн хянах боломж хязгаарлагдмал байдаг.

Зээлийн хүү нь зээлийн үнэ юм. Иймд зах зээл дэх бусад үнэтэй адил түүний өөрчлөлтийг эрэлт нийлүүлэлтийн хүчин зүйлс тодорхойлдог. Арилжааны банк болон бусад санхүүгийн байгууллагууд хуримтлалын нэг хэсэг болох харилцах, хадгаламжийн хэлбэрээр хөрөнгө татан төвлөрүүлдэг тул зээлийн нийлүүлэлт буюу хүүнд нөлөөлдөг. Судалгаанд хамрагдсан хугацааны туршид банкуудын татан төвлөрүүлсэн хөрөнгө нэмэгдэж, зээлийн нийлүүлэлтийг өсгөх эх үүсвэр болсноор зээлийн хүү буурахад нөлөөлжээ. Зээлийн хүү нь зээлийн төрөл, хугацаа, эрсдэл, зээлдэгч болон зээлдүүлэгч байгууллага зэрэг асуудлаас хамааран өөр өөр байдаг. Мөн зах зээлийн нөхцөлд эрэлт нийлүүлэлт хүүний хувийг тодорхойлдог боловч хүү энэ хэмжээнээс хэлбэлзэх нь өөр хүчин зүйлсээс шалтгаалдаг. Жишээ нь: макро эдийн засгийн байдал, инфляци, татварын ачаалал гэх мэт. Татварын хувь хэмжээ нь банкны орлого, өөрөөр хэлбэл ашигтай үйл ажиллагааны түвшинд нөлөөлдөг. Татварын дарамт их байх тусам ашгаа нэмэгдүүлэх зорилгоор зээлийн хүүг өсгөж болох талтай.

Манай орны макро эдийн засгийн таатай орчин, инфляцийн түвшин багасч тогтворжин, банкны салбарын эрүүлжилт, санхүүгийн зуучлал гүнзгийрэн банкууд хоорондын өрсөлдөөн нэмэгдэж, түүнийг даган хадгаламжийн хүү буурч, зээлийн хүү сүүлийн жилүүдэд буурах хандлага ажиглагдаж буй хэдий ч зээлийн хүү нь урт хугацааны хөрөнгө оруулалтыг дэмжих, эдийн засгийн өсөлтийг хангахуйц хэмжээнд хүртэл буурахгүй байгаад ямар хүчин зүйлс голлох нөлөөтэй байгааг ялган тодорхойлж, зээлийн хүүг бууруулахын тулд бодлогын хүрээнд ямар арга хэмжээ авч болохыг тодорхойлох нь чухал ач холбогдолтой байна. Мөн нөгөөтэйгээр манай улсад үнэт цаас хөрөнгийн захын сул дорой хөгжил, банкуудын урт хугацаатай хөрөнгө оруулалтын зээл олгох эдийн засгийн орчин сайн бүрдээгүй гэх мэт хүчин зүйлсээс шалтгаалж байна. Санхүүжилтийн эх үүсвэр олох нэг арга зам бол хувьцаа гаргаж хөрөнгийн зах зээл дээр борлуулах үйл ажиллагаа хөгжөөгүй тул зээлийн эрэлт нийлүүлэлтэд нөлөө үзүүлэхгүй байгаа нь зээлийн хүүд нөлөөлж байна.

Түүнчлэн зээлдэгчдийн хүүний хооронд ихээхэн зөрүү байдаг ба түүний гол шалтгаан нь тэдний эрсдэлтэй холбоотой байна. Өөрөөр хэлбэл, томоохон урт хугацаанд найдвартай хамтран ажилласан, барьцаа хөрөнгө сайтай томоохон зээлдэгчдэд зээл эргэн төлөгдөхгүй байх эрсдэл нь бага буюу зээлийн хүүнд шингээх эрсдэлийн үнэ нь бага байдаг тул зээлийн хүү доогуур байдаг. Харин жижиг, шинэ болон найдвартай эсэх нь мэдэгдэхгүй байгаа зээлдэгчдийн хувьд зээлийн хүүнд шингэх эрсдэлийн үнэ нь өндөр байдаг тул хүү нь өндөр байдаг. Богино хугацаатай зээлийг бодвол урт хугацаатай хөрөнгө оруулалтын зээл илүү их эрсдэлтэй байдаг. Зээлдэгч ба зээлдүүлэгчийг эрсдэлд оруулдаг олон хүчин зүйлс байдаг. Жишээ нь зээлдэгчийн мэргэжил чадвар дутагдаж, мэдээллийг буруу олж авах, улмаар бизнесийн үйл ажиллагаа нь дампуурах, улс орны эдийн засаг, санхүү хямрах, гадаад дотод зах зээлийн үнэ ханшийн тааламжгүй өөрчлөлт, ган зуд, газар хөдлөлт, хүн амын хладварт өвчин гарах гэх мэт. Зээлдэгч ба зээлдүүлдэгч хоёр энэ бүхнийг урьдчилан харж тооцох боломж байдаггүй. Урьдчилан харах боломжгүй эрсдэлийн хохирлыг зээлдэгч ба зээлдүүдэлгч хуваалцах талаар зээлийн гэрээнд тусгадаггүй бөгөөд харин эрсдэлийн болон даатгалын сангууд байгуулдаг

олон улсын практик байдаг байна. Эдгээр санг төр засгаас дэмжиж бодлогыг явуулдаг байна.

Хэдийгээр зээлийн хүү буурах хандлагатай байгаа боловч банкуудын санхүүгийн зуучлалын зардал харьцангуй өндөр хэвээр, ялангуяа хадгаламжийн хүү багасахгүй, зээлийн эрэлт их байсаар байгаа ба зээлдэгчдийн төлбөрийн сахилга бат сайжирсан ч зээл эргэн төлөгдөхгүй байх эрсдэл харьцангуй өндөр, хөрөнгийн захын сул дорой хөгжил, банкуудын орлого авчирдаггүй активийн нийт активт эзлэх хувь өндөр зэрэг нь зээлийн хүүг дорвитой бууруулахад сөрөг хүчин зүйл болж байна. Мөн зээлийн хүү дорвитой буурхагүй байгаа нь жижиг банкууд хоорондын болон банк бус санхүүгтйн байгууллагууд, хадгаламж зээлийн хоршоод хоорондын эх үүсвэрийн төлөөх хүүний өрсөлдөөнөөс шалтгаалж байна.